

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2025 оны 01 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
<b>Үүрэг, даалгавар ЕС:</b> Нийслэлийн теле камерын нэгдсэн төвийн засварын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр дуусгаж, системийг 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор хийж, 04 дүгээр сарын 01-ний өдөр нэгдсэн төвийн үйлчилгээг нээх, дүүргүүдийн дэд төвүүдийг холбогдох ажлуудаа шуурхай зохион байгуулж ажиллах.				
1	Теле хяналтын камерын дэд төвийн өргөтгөлийн дотоод тохижилт засварын ажил, сервер суурилуулалт, тоног төхөөрөмж холболтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Ногоон бүсийн теле хяналтын камерын төвийн дотоод сүлжээг тус дэд төвтэй холбох ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Мөн дэд өртөөний барилгын ажил болон дотор генератор бүрэн суурилагдсан бөгөөд ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. Цаашид гадна талбайн хог хаягдлыг цэвэрлэх, газар шороог тэгшлэх ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.		Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	70
<b>Үүрэг, даалгавар АРВАН ГУРАВ:</b> Ерөнхий боловсролын хичээлийн эхэлж байгаатай холбогдуулан томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, сургалтын байгууллагын суралцагч, багш, ажилтан, албан хаагчдыг дотоод орчинд амны хаалтыг тогтмол зүүлгэх, мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэх захирамж гаргах.				
2	Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдуулан дүүргийн Эрүүл мэндийн төвийн Халдварын сэргийлэлт, хяналтын албанаас хүүхдийн байгууллагад мөрдөж ажиллах эрүүл ахуйн дэглэм, амьсгалын замын халдварт өвчин, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн. Чингэлтэй дүүргийн харьяа Улсын болон хувийн хэвшлийн хүүхдийн байгууллагын эмч нарт 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр “Хүүхдийн байгууллагад мөрдөж ажиллах эрүүл ахуйн дэглэм”, “Амьсгалын замын халдварт өвчин, томуу, томуу төст өвчний үеийн хариу арга хэмжээ” сэдэвт сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.			100
<b>Үүрэг, даалгавар ХОРИН ГУРАВ:</b> Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах.				

3	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулдаг бөгөөд 2025 оны ээлжит урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгийн ажлыг 2025 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	30
<b>Үүрэг, даалгавар ХОРИН ЗУРГАА:</b> Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ цас мөс, хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх үйл ажиллагаагаа эрчимжүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих улсын байцаагч ажиллуулах, бүтэц орон тооны асуудлыг зохицуулах захирамж гаргах.				
4	Дүүргийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Дүүргийн 1-6 дугаар хороодын хог тээвэрлэлтийг шөнийн цагт шилжүүлэх тухай” А/09 дүгээр захирамж гарсан. Тус захирамжийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх ахуйн хог хаягдлыг оройны 18-21 цагийн хооронд гаргах, гаргасан хог хаягдлыг 21:00 цагаас өглөөний 05:00 цагт хүртэл нийт 100 гаруй байршилд 8 машин техникээр нэгдсэн хогийн цэг, ил задгай үүссэн үүсмэл хогийн цэг, орон сууц, байшин хорооллын хогийн цэг, аж ахуй нэгж, байгууллагын хогийн цэгийн хог хаягдлыг шөнийн турш тогтмол ачиж тээвэрлэн ажиллаж байна. Нийслэлийн Байгаль орчны газартай хяналтын Улсын байцаагчийг дүүрэгт томилон ажиллуулахаар тохиролцон бэлтгэл ажлыг хангаад байна.			100
<b>Үүрэг, даалгавар ХОРИН НАЙМ:</b> Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ золбин нохой, муур устгах ажлуудаа эрчимжүүлэх, хэрэгжилтэд Захирагчийн ажлын албанаас хяналт тавьж ажиллах.				
5	Дүүргийн хэмжээнд золбин нохой, муур устгах ажлыг гүйцэтгэхээр дүүргийн Засаг даргын Тамгын газартай “Их булаг А ТҮК” ХХК нь гэрээ байгуулж устгалын ажлыг хариуцан ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын байдлаар 1263 золбин нохойг устгалд оруулаад байна. Мөн дүүргийн 14, 18 дугаар хороодын нутаг дэвсгэрийн 158 га газрыг чөлөөлж, “Сэлбэ” дэд төвийг байгуулах ажлын чөлөөлсөн талбайд нохой устгалыг эрчимжүүлэн 7 хоног болгон самналт хийж устгалд оруулан ажиллаж байна.			100
<b>Үүрэг, даалгавар ХОРИН ЕС:</b> Суурьшлын бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд Захирагчийн ажлын алба хяналт тавьж ажиллах.				
6	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/07 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/03 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс 2024 оны 11 дүгээр сарын 01-нээс хойш нийт хас тамгатай 20 тооны бараан зүсмийн адуунуудыг Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр рүү гаргаж ажилласан.			100

**Үүрэг, даалгавар ГУЧИН НЭГ:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хот нийтийн аж ахуйн чиг үүргийн хүрээнд дүүргүүдэд ажиллах тул бэлтгэл хангах.

7	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн чиг үүргийн дагуу дүүргийн хэмжээнд хот нийтийн аж ахуйн чиглэлээр хог хаягдлын ачилт, цуглуулалт, тээвэрлэлт, тохижилт, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалт, эзэнгүй нохой устгал зэрэг чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай чиг үүргийн дагуу гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд байгууллагуудын бэлтгэл ажлыг сайтар хангуулсан.		Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	70
---	---	--	---	----

**Үүрэг, даалгавар ГУЧИН ГУРАВ:** Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ хог их хаядаг байршлуудад хяналтын камер суурилуулах ажлыг зохион байгуулах.

8	Дүүргийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Дүүргийн 1-6 дугаар хороодын хог тээвэрлэлтийг шөнийн цагт шилжүүлэх тухай” А/09 дүгээр захирамж гарсан. Тус захирамжийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх ахуйн хог хаягдлыг оройны 18-21 цагийн хооронд гаргах, гаргасан хог хаягдлыг 21:00 цагаас өглөөний 05:00 цагт хүртэл нийт 100 гаруй байршилд 8 машин техникээр нэгдсэн хогийн цэг, ил задгай үүссэн үүсмэл хогийн цэг, орон сууц, байшин хорооллын хогийн цэг, аж ахуй нэгж, байгууллагын хогийн цэгийн хог хаягдлыг шөнийн турш тогтмол ачиж тээвэрлэн ажиллаж байна. Мөн ил задгай үүсдэг албан бус хогийн цэгийн байршлын нэгдсэн судалгааг гаргаж нэгтгэн тухайн бүсэд камер суурилуулж нэгдсэн камерын төвтэй холбохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	30
---	--	--	---	----

**ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ** **75%**